

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДЭД¹⁶¹ ХҮЛЭЭЛГЭХ САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ¹⁶² АСУУДАЛ

PROBLEM OF LEGAL ENVIRONMENT OF THE DISCIPLINARY PUNISHMENTS IMPOSED TO INMATES



Н.Гантулга. ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, хурандаа
Gantulga.N. Director of Institute of Execution of court decision, Law Enforcement University, Ph.D, Associate professor, colonel

Abstract: Some suggestions and recommendations of the researchers which are considered to have theoretical and practical importance in problems of disciplinary punishments imposed to inmate, are expressed in the scientific report.

Хорих ял эдлэгсдэд сахилгын шийтгэл хүлээлгэх асуудал олон улсын түвшинд “хорих ял эдлэх нөхцөл”, “хорих ял эдлэгсэдийн эрх, үүрэг” болон хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч хууль сахиулагчдын ажил үүрэг, эрүүгийн ял шийтгэлийн “ялтныг нийгэмшүүлэх /засан сайжруулах/” зорилготой нягт уялдан зохицуулагддаг байна.

Тэгвэл манай орны судлаачдын бүтээл¹⁶⁴ эрх зүйн

эх сурвалж, практик байгууллагын нийтэд зориулсан мэдээ-тайланд¹⁶⁷ энэ асуудал “хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, дэглэмийг сахиулах арга хэрэгсэл” институтын хүрээнд л хөндөгдөн хэлэлцэгдсээр хэвшжээ.

Иймд судалгааны баримтуудад түшиглэн асуудлыг хөндөн хэсэгчилсэн дүгнэлт-саналаа илэрхийлэхийг зорьлоо.

¹⁶⁴ Нэг талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын /2002 оны/ хуулийн 115 зүйл, 127 зүйл болон холбогдох бусад зүйл-хэсгүүдэд/ “ялтан”, нөгөө талаас олон улсын /тухайлбал: НҮБ-ын Эдийн засаг нийгмийн зөвлөлийн 1957 оны 663с/XXIY/, 1977 оны 2076 /LXII/ тогтоолоор сайшаагдсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-үүд зэрэг/ нийтлэг баримт бичгүүд, түүнчлэн манай орны төрийн гүйцэтгэх дээд эрх мэдлийн болон захиргааны төв, салбарын удирдах байгууллагуудаас гаргасан эрх зүйн зарим дэд актуудад /тухайлбал: Засгийн газрын 2002 оны “Хорих байгууллагын алба хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам батлах тухай” 217-р тогтоол, хуульзүй, дотоод хэргийн сайдын 1994 оны “Хоригдлын хоол, хувцас, ор дэр, цагаан хэрэглэл, ариун цэврийн хэрэгсэлийн норм, олгох заавар” батлах тухай 25-р тушаал зэрэгт/ “хоригдол” гэсэн нэр томъёог тус тус хэрэглэсэн байдаг ба нийтлэлийн хүрээнд асуудлыг хоёрдмол утгагүйгээр шууд илэрхийлэх зорилгоор энэ нэр томъёог хэрэглэлээ.

¹⁶⁵ Эрх зүйн орчин гэсэн нэр томъёог тухайн харилцааны эрх зүйн зохицуулалт, практик хийгээд түүний талаарх эрх зүйн ухамсар, соёлыг багтаасан агуулгаар хэрэглэв.

¹⁶⁶ С.Нарангэрэл “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал” УБ.1985 он; С.Жанцан, А.Лхагва

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДЭД САХИЛГЫН ШИЙТГЭЛ ХҮЛЭЭЛГЭЖ ИРСЭН БОЛОН ӨНӨӨ ҮЕИЙН МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ, ПРАКТИК

Монгол улсад шинэ үеийн эрх зүй¹⁶⁸ бүрэлдэн тогтож энэ хүрээнд хорих ял, түүнийг эдлүүлэх байгууллага, хорих ял эдлэгсэд бий болсон үеэс тэдний гаргасан эрх зүйн зөрчлийг хянан шийдвэрлэж сахилгын шийтгэл хүлээлгэх асуудал

“Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй” УБ.1996 он, 152-153 тал; Б.Дашзэвэг “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй/тусгай анги/-2” УБ.2004 он, 98-100 тал; А.Лхагва “Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй /Ерөнхий, тусгай ангийн сурах бичиг/” УБ.2004, 2009, 2012 он, 224-225 тал

¹⁶⁷ www.cd.gov.mn

¹⁶⁸ Ж.Болдбаатар, Лүндээжанцан “Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ.1997 он; С.Нарангэрэл “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо /харьцуулсан эрх зүйг/ УБ. 2001он, 91-92 тал, 101-110 тал

ямар нэг хэмжээгээр эрх зүйн хувьд журамлагдан зохицуулагдсаар өнөөг хүрчээ.

Харин хорих ял эдлэгсдийн ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд тооцох, түүнийг үйлдсэний учир хариуцлагын ямар арга хэмжээг хэн, хэрхэн хүлээлгэн шийдвэрлэж ирэв гэдэг нь тухайн цаг үеэдийн төр засгийн бодлогоор тодорхойлогдон өөрийн онцлогыг илэрхийлж байна. Тодруулбал манай оронд орчин үеийн эрх зүй бүрэлдэн бий болсон 1921 оноос хойшхи эрх зүйн эх сурвалж дахь “хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэл” институтэд анализ хийн зохицуулалтын адил төстэй шинжээр нь дараах түүхийн /хөгжлийн/ үе шатанд судлаачийн зүгээс хуваалаа. Энэ нь:

- 1921 оны 7-р сараас 1966 оны 3 сар
- 1966 оны 4-р сараас 1993 он
- 1994 оноос өнөө үе болно.

Түүхийн нэгдүгээр шатны онцлогыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Энэ шатыг дотор нь: а) 1921 оны 7-р сараас 1931 оны 4-р сар; б) 1931 оны 5-р сараас 1966 оны 3-р сар гэсэн 2 дэд шатанд хуваавал зохилтой.

Учир нь хувьсгалын эхний жилүүдэд шорон гяндантай холбоотой төр засгийн бодлого шийдвэрүүд хуучны ёс, дэглэмийг халж европын орнуудын хууль зүйн зарчим, хэм хэмжээг баримжаалан өөрийн орны онцлогыг харгалзан хэрэгжүүлэх оролдлоготой холбогдож байсан юм.¹⁶⁹

Тэгвэл 1930-аад оноос эхлэн ЗСБНХОУ-ын Коминтерны шахалт шаардлагаар “социализмын зөвлөлтийн загвар”-ыг монгол оронд хуулбарлан нутагшуулах ажиллагаа өрнөж хувьсгалын дараа батлагдсан хууль эрхийн актуудыг эргэн засварлаж эхэлсэн ба энэ хүрээнд ЗСБНХОУ-ын Засан

хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1924 оны хуультай олон талаар адил “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, яланг засан сайжруулах ажлын тухай” анхны салбарын хууль 1931 оны 4-р сард батлагдсан түүхтэй.¹⁷⁰ Хэдийгээр түүний олон заалтууд салбарын дараагийн хуулиудын загвар болон уламжлагдан хадгалагдсан боловч 1936 оноос Засан сайжруулах газар,¹⁷¹ Шүүх яамнаас Дотоод Явдлын Яамны харьяанд шилжин очсноор хуулийн үйлчлэл үндсэндээ зогсч түүнийг 1966 оны 03 сарыг дуустал ДЯЯ-ны сайдын тушаалууд орлох болсон.

2. Энэ шатанд хорих газруудын хооронд дэглэмийн ялгаа байгаагүй.

3. Хорих ял эдлэгсдээр хүнд ажил хийлгэх нь сахилгын шийтгэлийн төрөл болон хуульчлагдсны гадна ихэнхи тохиолдолд түүнийг хэрэглэдэг практик байсан. /хуулийн 7-р бүлэг, 56-р зүйл, 5 хэсэг/

4. Сахилгын зөрчлийн учир тусгай тасалгаанд хоригдсдыг 3 өдөрт 1 удаа гадаалуулах журам байв. / хуулийн 7-р бүлэг, 56-р зүйл, 4 хэсэг /

Түүхийн хоёрдугаар шатны онцлог нь:

1. Энэ шатанд салбарын хууль 1966, 1981 онуудад “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” нэрээр батлагдсан ба хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэл тооны хувьд нэмэгдэх болсон.¹⁷²
2. Торгуулийн тусгаарлах байранд хорих сахилгын шийтгэлийн хугацаа уртассан.¹⁷³
3. Хорих байгууллагын дэглэмийг дээшлүүлэх явдал сахилгын шийтгэлийн хамгийн хатуу төрөл болсон.

¹⁷⁰ Гэвч хуульд өөрийн онцлогийг илэрхийлсэн зохицуулалтууд /тухайлбал, 4-р бүлгийн 14 зүйлийн тайлбарлах нь хэсэгт: “... хянан харгалзах комиссын тогтоолоор ажилд онц хичээлтэй бөгөөд уул ажлын дадлыг олсон жинхэнэ ард ял эдлэгсдийн ажил хийсэн 2 өдрийг хорих буюу хорихгүйгээр албадан ажил хийх хугацааны 3 өдөрт тооцож урамшуулбаас зохимой ...” / байсан.

¹⁷¹ Гяндан салааг 1930 оноос Улсын Засан сайжруулах газар гэж нэрлэх болсон.

¹⁷² Тухайлбал: 1966 оны хуульд сануулах, ээлжит илгээлтийг хасах /21-р зүйл 1 хэсэг/, 1981 оны хуульд хорих газрын байр орчныг цэвэрлүүлэх, ээлжийн бус дежурт гаргах, хүнсний зүйл худалдан авахыг 1 сар хүртэл хугацаагаар хасах, ял эдлэх нөхцөл байдлыг сайжруулсныг хүчингүй болгох /51-р зүйл/сахилгын шийтгэлийн төрлүүд нэмэгдэж хуульчлагдсан.

¹⁷³ Тухайлбал: Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониудад -30 хүртэл, Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн сахилгын байранд 10 хүртэл хоног, хэрэв засралгүй, тогтоосон дэглэмийг ноцтойгоор зөрчвөл Хянах комиссын тодорхойлолт, колонийн даргын саналыг үндэслэн ЗХБУГ-ын даргын тушаалаар жирийн ба чанга дэглэмтэй колониудад 2 сар хүртэл, онцгой дэглэмтэй колонийн торгуулийн тусгаарлах байранд 3 сар хүртэл хугацаагаар хорих журам үйлчилж байсан. Харин 1966 оны хуулиар гяндангийн ялтыг хорих тасалгаанд гяндангийн даргын тушаалаар 30, ЗХБУГ-ын даргын тушаалаар 3 сар хүртэл хорих буюу гяндангийн хатуу дэглэм шилжүүлэх, 1981 оны хуулиар гяндангийн даргын тушаалаар 20 хүртэл, жирийн дэглэмтэй гяндангийн ялтыг чанга дэглэмтэй гянданд 6 сар хүртэл хугацаагаар шилжүүлэх журамтай байжээ.

¹⁶⁹ Тухайлбал: 1924 оны 11-р сард хуралдсан Монгол Ардын Намын III их хурлын тогтоолд: “Гянданаа хоригдон бүхий хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал нэн муу байгааг даруй сайжруулах, насанд хүрээгүй хөвгүүд, охид хэрэгт холбогдож аваас гянданаа хорихгүйгээр гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв, засрах байдалтайгий нь гянданаа хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих зэргийг онцлон...”, Улсын анхдугаар Их Хурлын тогтоолын Шүүх яамны тухай хэсэгт: “Их гяндан ба улсын доторхи олон албан газруудын байдлыг цөм европын байдалд нийцүүлэх, аливаа ялтан, хэрэгтний бие махбодид харшгүй зохих гяндангуудыг шинэчлэн байгуулах, ялтнуудыг үйлдвэрт зүтгүүлэх, сүрган гэгээрүүлэх ажлыг харьяа Шүүх яамнаас даруй эрхлэн явуулахын чухлыг...” тус тус онцлон тэмдэглэжээ. Мөн төр засгийн зүгээс хувьсгалын эхний жилүүдэд шоронг шинэчлэн байгуулах, хоригдогсдыг ажил үйлдвэрлэлд хамруулах, сургаж гэгээрүүлэх, ахуй нөхцлийг нь сайжруулахад ихээхэн анхаарч байсны дүнд 1925 оны 5-р сарын 09-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Их гянданг сайжруулах тухай” 16 зүйл дүрэм батлагдсан, 1929 оны 9-р сард Улсын Төв гяндангийн шинэ барилга ашиглалтад орж ялтнууд нүүн шилжсэн баримтууд байна. //Дэлгэрүүлж үзнэ үү: А.Лхавгаа Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болох өргөжсөн түүхэн замнал /1921-2001/тэргүүн дэвтэр” УБ.2001 он, 10-11 тал.

4. Салбарын төрөлжсөн үе үеийн бусад хуулиудтай харьцуулахад БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1981 оны хуульд “хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэлийн асуудал” илүү нарийвчлагдан, дэвшилтэйгээр тусгагджээ.¹⁷⁴ Тухайлбал:
 - а) Энэ хуульд сахилгын шийтгэл хамгийн олон төрлөөр хуульчлагдсан¹⁷⁵ ба энэ нь хорих ял эдлэгсдийн гэмт үйлдэл, эс үйлдэхгүйг ялгамжтайгаар зүйлчлэх, тэдэнд тохирсон арга хэмжээг хүлээлгэх боломжийг нэмэгдүүлсэн гэх үндэстэй.
 - б) спорт тоглоомд оролцох, кино, концерт үзэхээс 1 удаа хасах шийтгэлийг хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгаа ялтанд тусгайлан оногдуулж болохоор хуульчилсан.
 - в) Сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх хугацаа¹⁷⁶, журам, сахилгын шийтгэлгүйд тооцогдох үндэслэл, ганцаарчилсан хатуу тасалгаа /карцер/, торгуулийн болон сахилгын тусгаарласан байранд мөрдөх журмыг хуульчилсан.¹⁷⁷
 - г) Сахилгын шийтгэл хүлээлгэх субъект, тэдгээрийн эрх хэмжээг ялгамжтайгаар тогтоосон.¹⁷⁸ Гэхдээ хуульд зарим хүнлэг бус зохицуулалт тусгагдсныг ч¹⁷⁹ тэмдэглэх ёстой. Туухийн 3-р шатны онцлог нь:
 1. Энэ шатанд салбарын хуулиуд “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай” /1993 онд/, “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай” /1996 онд/, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль нэрээр батлагдан үйлчилсэн, мөн 1993, 1996 оны хуулиудад “хоригдол” гэсэн нэр томъёог хэрэглэсний гадна зөрчил гаргагчдад хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрөл, журам нь адил байдлаар хуульчлагдсан.
 2. Эдгээр хуулиудад “сануулах”, “донгодох” арга хэмжээ сахилгын шийтгэлийн төрлөөс хасагдсаны зэрэгцээ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай 1981 оны хуулиар урамшууллын хэлбэрээр олгогдож эхэлсэн “ажлын хоног”¹⁸⁰ -ийг “шагналын хоногийг хасах”¹⁸¹ гэсэн нэр томъёогоор шинээр шийтгэлийн төрөл болгон хуульчилсан.
 3. Сахилгын байранд хоригдсон ялтны ээлжит түр, удаан хугацааны уулзалтыг хасахыг хориглох дэвшилттэй заалт 1996 оноос хуульд тусгагдан өнөөг хүрсэн.

Гэвч хуулийн энэ хэм хэмжээг зөрчсөн журмыг салбарын төрийн захиргааны төв байгууллагаас¹⁸² тогтоосон ба хорих байгууллагуудыг удирдах дээд шатны албан тушаалтнуудаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу энэ журмыг өнөөг хүртэл дагаж мөрдсөөр байна.

Энэ бүгдээс үзвэл хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэлийн асуудал үе үеийн салбарын хуулиудад¹⁸³ “эрх зүйн институтын” түвшинд зохицуулагдаж ирсэн байх ба энэ нь уг асуудалд төр засгийн зүгээс онцгойлон ач холбогдол өгч ирснийг илтгэж байна.

Хэрэв хорих ял эдлэгсдийн зүгээс гаргасан гэмт хэрэг, зөрчлийн төрөл /өнгө/, тоо, шалтгаан нөхцлийг судалгааны баримтуудад үндэслэн дүгнэн үзвэл голлох байдлаар дараах хүчин зүйлстэй холбон тайлбарлаж болох юм. Энэ нь:

 - Улс орны тухайн цаг үеийн хөгжлийн түвшин, нийгэм, эдийн засгийн боломж, бодит байдал
 - Хорих ял эдлэгсдийн тоо, бүрэлдэхүүн, хорих ялын хугацаа

¹⁷⁴ “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж” УБ.2013 он, 82-84 дэх тал. //Эмхэтгэсэн А.Лхагва

¹⁷⁵ Хуулийн 51-р зүйл

¹⁷⁶ Хуулийн 52-р зүйл “...Сахилгын арга хэмжээг зөрчлийг илэрүүлснээс хойш 10 хоногийн дотор оногдуулна. Хэрэв уг зөрчлийн талаар шалгалт явуулсан бол түүнийг дууссан даруй арга хэмжээг оногдуулах боловч зөрчил гаргаснаас хойш 6 сараас хэтрүүлж болохгүй. Сахилгын арга хэмжээг хэрэв өөр журам тогтоогоогүй бол ЗХХБ-ын даргын тогтоолоор оногдуулна ... Ялтан 1 жилийн дотор дахин сахилгын арга хэмжээ авагдаагүй бол сахилгын арга хэмжээ авагдаагүйд тооцогдоно”

¹⁷⁷ Хуулийн 52-р зүйл “... Ганцаарчилсан хатуу тасалгаа /карцер/ торгуулийн болон сахилгын тусгаарласан тасалгаанд байгаа ялтанд бусадтай уулзах, захидал явуулах, хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйл, эргэлт, илгээлт авах, тоглоом тоглох, тамхи татахыг хориглоно...”

¹⁷⁸ Хуулийн 53-р зүйл “ЗХХБ-ын дарга, түүний бүх дээд шатны дарга нар сахилгын арга хэмжээг бүрэн авах эрх эдэлнэ. ЗХХБ-ын орлогч дарга нь ялтныг торгуулийн буюу сахилгын тусгаарласан тасалгаа, ганцаарчилсан хатуу тасалгаанд шилжүүлэхээс бусад эрхийг эдэлнэ. Колонийн отрядын дарга сануулах, донгодох /амаар/, хорих газрын байр, орчныг цэвэрлүүлэх, ээлжийн бус дежурт гаргах, хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа ялтныг кино, концерт үзэх, спорт тоглоомд оролцохыг 1 удаа хасах сахилгын шийтгэл оногдуулах хэрэгтэй. Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн хүмүүжүүлэгч сануулах буюу донгодох сахилгын арга хэмжээ ноогдуулах эрхтэй”.

¹⁷⁹ Ганцаарчилсан хатуу тасалгаа (карцер) болон торгуулийн тусгаарласан байранд байгаа ялтныг гадаалуулахгүй бөгөөд ганцаарчилсан хатуу тасалгаа (карцер)-нд байгаа ялтанд хөнжил, гудас олгохгүй. Харин торгуулийн тусгаарласан тасалгаанд 30 хоногоос дээш хугацаагаар байгаа ялтанд хөнжил, гудас олгоно.

¹⁸⁰ Хуулийн 49-р зүйл “... бүтээлийн нормоо давуулан биелүүлж, гарамгай амжилт гаргасан тохиолдолд хөдөлмөрийн нөхцлийг харгалзан БНМАУ-ын НАХЯ-наас тогтоосон журмын дагуу ажлын хоног олгох”

¹⁸¹ Хуулийн 30-р зүйлийн 1.4 “Тухайн улирал эсвэл жилд олгосон шагналын хоногийг хасах”

¹⁸² Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам” батлах тухай 2002 оны 11-р сарын 30-ны өдрийн 270 дугаар тушаалын 5.9-д: “Сахилгын байранд хоригдож байгаа ялтан онцгой тохиолдолд ангийн даргын зөвшөөрлөөр түр хугацааны уулзалт хийх эрхтэй” хэмээн тусгагдсан.

¹⁸³ Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай /1931 оны/, БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн /1966, 1981 онуудын/, Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай /1993 оны/, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай /1996 оны/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002 оны/ хуулиуд

- Хорих байгууллагын байршил, дэглэмийн шаардлага, харуул хамгаалалт, хяналтын тогтолцоо, алба хаагчдын нөөц, ур чадвар
- Хорих ял эдлэгсдийн орон байр, ахуй, хүнсний хангамж
- Хөдөлмөрийн нөхцөл, ажлын нормчлол зэрэг болно.

Иймд эдгээр шалтгаан нөхцлийг харгалзан хорих ял эдлэгсдийн гэмт хэрэг, зөрчлийн төлөв байдлыг дараах 4 түүхийн үед хуваан тоймлож болно. Энэ нь:

- Хорих газрууд бий болсон эхний жилүүдээс 1960-аад оны 2-р хагас хүртэл дэглэмийн ялгаа зааг бараг байхгүй байсан¹⁸⁴, харуул хамгаалалт, хяналтын механизм сул, алба хаагчдын тоо цөөн, хангамж, мэргэшсэн чанар нь шаардлагын түвшинг хангахгүй байсан¹⁸⁵ зэрэг хүчин зүйлстэй уялдан илэрсэн, шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо бага байсан магадлал өндөр байна.
- Харин 1970-1990 оны хооронд эрүүгийн ялын бодлого, ялангуяа хүн амь, дээрэм, танхай, социалист өмчийн гэмт хэрэг үйлдэгчдийн харьцаанд чангарч хоригдлын тоо эрс нэмэгдсэн, хорих дэглэм, ял эдлүүлэх нөхцлүүд ялгамжтай болсон, хоригдлуудын орон байр, ахуй, хөдөлмөрийн нөхцөл тааламжгүй, ажлын ачаалал их, алба хаагчдын хүний нөөцийн дутмаг байдал болон зарим ялтнууд /бригад, ялтны зөвлөлийн дарга зэрэг/ “бичигдээгүй хуулиар” илүү эрх дарх эдлэх болсонтой уялдан нэг талаас хоригдлуудын, нөгөө талаас алба хаагч, хоригдол хоорондын харьцааны зөрчил хурцдах, бие биеийнхээ эрх чөлөөнд халдах, дарамтлах зэрэг зүй бус үйлдлүүд, согтууруулах ундаа хэрэглэх, мөрийтэй тоглох, хорих газраас оргох гэмт хэрэг, зөрчлүүд давамгайлж байсныг түүхэн эх сурвалжийн баримт бичгүүд болон судалгаагаар тодорхойллоо¹⁸⁶.
- Мөн 1990-2000 оны эхэн үе хүртэл нэг талаас улс орны нийгэм, эдийн засгийн хямрал, хүн амын ёс суртахууны доройтол /өнгө-мөнгийг хэт шүтэн “хэн сүйхээтэй, зальжин нь зах зээлийн нийгэмд сайхан амьдрах боломжтой” гэсэн нийтлэг яриа, нийгмийн сэтгэл зүй/, нөгөө талаас зарим хорих

ангиуд орон нутгийн харьяалалтай болсон, санхүүжилт нь хүндэрсэн, хоригдлуудын ажлын байр хумигдсан, алба хаагчдын тоо цөөрсөн¹⁸⁷, хоригдолд тавих шаардлага суларсан зэрэг бусад хүчин зүйлстэй уялдан бие биеийнхээ эрх чөлөөнд халдах, эд зүйлсийг булаах, дээрэмдэх, хулгайлах, согтууруулах ундаа хэрэглэх, алба хаагчдыг эсэргүүцэх, ажлын байр, хорих зонныг дур мэдэн орхин явах, хорих ангиас оргох хэрэг, зөрчлийн тоо буураагүйн зэрэгцээ аюул занал нь нэмэгдсэн гэж онцолж болно. Түүнчлэн “хар сав шарах”¹⁸⁸, “хар малгайтай”¹⁸⁹, “зарим эд зүйл урлах”¹⁹⁰-ыг сахилгын зөрчилд тооцон тэмцэж байсныг өнөөдөр эргэн харахад ихээхэн шүүмжлэлийг өрнүүлж болох юм.

- 2000 оны дунд үеэс хорих анги төвлөрсөн бүтцэд бүрэн шилжиж, харуул хамгаалалт, хяналтын техник хэрэгсэл, байгууламж сайжирсан, алба хаагчдын

боловсрол, мэргэжлийн түвшин, ур чадвар, цалин хангамж нэмэгдсэн, хоригдлын орон байр, хоол хүнс, ахуйн нөхцөл ихээхэн дээшилсэнтэй уялдан тэдний зүгээс үйлдэх эрх зүйн зөрчил, гэмт хэрэг тооны хувьд буурах хандлага ажиглагдсан. Гэвч хорих ял эдлэгсдийн бүтцэд гарсан өөрчлөлт¹⁹¹, мөн улс төрийн зарим шийдэл¹⁹², телевиз, радио, сонин, сэтгүүл зэрэг олон нийтийн хэрэгслээр үе үе цацагдаж буй хэт туйлширсан, хариуцлагагүй мэдээ-мэдээллүүд нь ял эдлэгсдийн сэтгэл зүй, зан байдал, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж багагүй тохиолдолд тэднээс зөрчил¹⁹³, гэмт хэрэг гаргах сэдэл болж аюул заналыг өсгөх магадлал байна¹⁹⁴.

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДЭД ХҮЛЭЭЛГЭХ САХИЛГЫН ШИЙТГЭЛ ЭРХ ЗҮЙН ИНСТИТУТИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

¹⁸⁷ А.Лхавга “дурьдсан бүтээл”. Мөн алба хаагчдын цалин, бусад хангамж нь хувь хүн, айл өрх, нийгмийн хэрэгцээ, шаардлагаас хол хоцросон, түүнчлэн 20 жил алба хаасан олон ажилтныг цэргийн байнгын тэтгэвэрт гаргасан.

¹⁸⁸ Хоригдлууд зөвхөн нийтийн хоолонд орох үүрэгтэй ба тэднээс ялтны байр, үйлдвэрлэлийн талбар зэрэг газруудад зөвшөөрөлгүйгээр хоол бэлтгэн хэрэглэхийг зөрчилд тооцдог байсан.

¹⁸⁹ Ялтнуудад дугуй хар малгай өмсөхийг хориглож байсан.

¹⁹⁰ “Гяндан” цэцэг хийх нь зөрчилд тооцогддог байв.

¹⁹¹ Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэн олон жилээр шийтгэгдсэн идэр насны ялтны тоо нэмэгдсэн, мөн нийгэмд нэр нөлөө бүхий өндөр албан тушаалтан, эрх мэдэлтэн, хөрөнгө мөнгөтэй, боловсрол, мэдлэгтэй, зарим тохиолдолд хэт /“үндэсэрхэг” / үзэлтнүүд хоригдох болсон.

¹⁹² Өршөөл үзүүлэх тухай хуулиудыг УИХ-аас 1991, 1996, 2006 онуудад гаргасан ба зарим ял эдлэгсдэд хуулийн үйлчлэл хамраагүй.

¹⁹³ Тухайлбал: алба хаагчид, дэглэмийн шаардлагыг бүлэглэн, зохион байгуулалтайгаар зөрчих, биелүүлэхгүй байх, эсэргүүцэх, заналхийлэх зэрэг.

¹⁹⁴ Судлаачдын хийсэн дээрх социологийн судалгааны материалд тулгуурласан.

¹⁸⁴ Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай /1931 оны/, БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн /1966 оны/хуулиудад анализ хийн үзвэл.

¹⁸⁵ Л. Чүлтэмсүрэн “Засан хүмүүжүүлэх байгууллагын товч түүх” УБ. 1979 он /дам ишлэв/ А.Лхавга “Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал /1921- 2001/УБ.2001 он, 149-150 дах тал

¹⁸⁶ С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол-1” УБ.2009 он, 97-102 тал; А.Лхавга “дурьдсан бүтээл”116-130, 150-170 дах тал. Мөн судлаачдын зүгээс 2014 оны 02-р сарын 12-15-ны өдрүүдэд болсон ШШГЕГ-ын анги-албадын удирдах ажилтны зөвлөгөөн болон 2014 оны 03-р сарын 14-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулиас үе үеийн багш-ажилтнуудынхаа дунд зохион байгуулсан өдөрлөгийн үеэр авсан социологийн /ярилцлага, хэлэлцүүлэг/ судалгааны материалын дүн.

Хүний эрх, тэр дотроо хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамааралтай олон улсын эрх зүйн нийтлэг эх сурвалжийн “хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэл” эрх зүйн институтын зохицуулалтаас:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын¹⁹⁵

- “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”. /5-р зүйл/

Иргэний болон улс төрийн эрхийн тухай

олон улсын пактын¹⁹⁶

- “... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй”. /9-р зүйл/
- “Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана”. /10-р зүйл 3 хэсэг/

Хуухдийн эрхийн конвенцийн¹⁹⁷

- “Эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрт насных нь хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг харгалзан нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг хандана”. /37-р зүйл “с”/
- “... гэм буруутай нь тогтоогдсон хүүхдэд хамаарах хууль, журам, тусгай байгууллага, алба байгуулахад тус дөхөм үзүүлбэл зохино”. /40-р зүйл 3 хэсэг/

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг

дүрүүдийн¹⁹⁸

- Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс, нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй хэрхэн харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад эсхүл нэг хорих газрын өөр өөр хэсэгт байлгана /8-р зүйл/
- Хоригдлуудыг тухайн хорих газрын үйлчилгээнд сахилгын арга хэмжээ болгон ажиллуулж болохгүй /28.1-р зүйл/
- Дараах зүйлийг хуулиар эсхүл эрх бүхий захиргааны байгууллагын шийдвэрээр тодорхойлох ёстой:

а/ сахилгын зөрчилд тооцогдох зан үйл

б/ хоригдолд оногдуулж болох шийтгэлийн төрөл, хугацаа

с/ шийтгэл оногдуулах эрх бүхий байгууллага. /29-р зүйл/

- Шийтгэлийг зөвхөн дээрх хууль, шийдвэрийн дагуу оногдуулах бөгөөд нэг ч хоригдолд нэг үйлдэлд давхар шийтгэл оноож болохгүй /30.1-р зүйл/
- Хоригдлыг ямар үйлдэлд буруутгаж байгааг урьдчилан мэдээлж өөрийгөө хамгаалах зохих боломж олгохгүйгээр шийтгэж болохгүй бөгөөд эрх бүхий байгууллага ийм төрлийн хэрэг бүрийг маш нягт нямбай хэлэлцэж шийдвэрлэх ёстой /30.2-р зүйл/
- Чанга дэглэмд хорих, хоол ундыг нь хасах шийтгэлийг гагцхүү хоригдлыг эмчийн үзлэгт оруулж уг хоригдол энэ шийтгэлийг эдэлж чадахыг бичгийн хэлбэрээр тодорхойлсны дараа оногдуулж болно /32.1-р зүйл/
- Эмч нь ийм шийтгэл хүлээсэн хоригдлуудыг өдөр бүр эргэж, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан шийтгэлийг өөрчлөн эсхүл зогсоох шаардлагатай гэж үзвэл захиралд саналаа тавьж болно. /32.3-р зүйл/ Европын хорих ял эдлүүлэх дүрмүүдийн¹⁹⁹
- Хамтаар нь шийтгэх, бие махбодын шийтгэл, цонхгүй хатуу тасалгаа /карцер/-нд хорих болон бусад хүнлэг бус, нэр төрийг нь гутаан доромжилсон шийтгэлийг хориглоно /60.1-р зүйл/
- Шийтгэл нь гэр бүлтэйгээ харьцах харьцааг бүрэн хориглох ёсгүй /0.4-р зүйл/
- Хөдөлгөөнийг хязгаарлах хэрэгсэл болгон шийтгэлийг хэрэглэх ёсгүй /60.6-р зүйл/ гэсэн заалтуудыг онцгой ач холбогдолтой гэж үзлээ. Мөн манай хөрш ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуулийн “яланд хүлээлгэх сахилгын шийтгэл эрх зүйн институт”-д хамаарах зохицуулалтаас²⁰⁰:
- Сахилгын шийтгэлийн төрөл /115-р зүйл, 116-р зүйл/
- Сахилгын шийтгэл хүлээлгэх журам /117-р зүйл/
- Торгуулийн тусгаарлах байр, хатуу тасалгаат байр, хатуу тасалгаа бүхий нэгдсэн байр, ганцаарчилсан тасалгаанд хоригдогсдийн нөхцөл /92-р зүйл, 118-р зүйл/
- Сахилгын шийтгэл хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан /119-р зүйл/
- Насанд хүрээгүй яланд хүлээлгэх сахилгын шийтгэл /136-р зүйл, 137-р зүйл/ зэрэг асуудалд

¹⁹⁵ НҮБ-ын Ерөнхий Ассесблейн 217 /А/114/ тогтоолоор 1946 оны 12-р сарын 10-ны өдөр баталсан //Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. УБ.2002.8 тал

¹⁹⁶ НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1966 оны 12-р сарын 16-ны 2200А /XXI/ тогтоолоор баталж, 1976 оны 3-р сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон //мөн бүтээлийн 15-16 тал

¹⁹⁷ 1989 оны 11-р сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9-р сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁹⁸ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын 1-р хурлаар баталж Эдийн засаг нийгмийн зөвлөлийн 1957 оны 7-р сарын 31-ны өдрийн 663 с /XXIY/ 1977 оны 5-р сарын 01-ны 2076/LXII/ тогтоолоор сайшаасан.

¹⁹⁹ <http://www.zagr.org/256htm>; http://www.hrpublishers.org/site-files/library/sb-02_rdf //Европын Холбооны Сайд нарын Хорооноос 2006 онд баталсан “Европейские пенитенциарные правила”

²⁰⁰ <http://www.consultant.ru> /document/coc_doc_LAW_158447. Уголовно-исполнительный кодекс Российской Федерации от 08.01.1997 №1 ФЗ (ред... федерального закона от 02.07.2013 №185 фз)

онцгой анхаарал хандуулан харьцуулан судлах шаардлагатай гэж судлаачдын зүгээс үзсэн.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Илтгэлд дурьдсан судалгааны баримтуудад тулгуурлан дараах хэсэгчилсэн дүгнэлтийг хийж байна. Энэ нь:

1. Зөрчил гаргасан хорих ял эдлэгсдэд сахилгын шийтгэл хүлээлгэх асуудал үе үеийн салбарын хуулиудад “эрх зүйн институтын” түвшинд зохицуулагдаж ирсэн нь төр засгийн зүгээс асуудалд онцгойлон ач холбогдол өгч ирснийг илтгэхийн зэрэгцээ үзэл суртал болон объектив, субъектив бусад хүчин зүйлсээс шалтгаалан тэдгээрийн зарим дэвшилтэт хэм хэмжээ нь орхигдож өнөөдрийг хүрчээ.
2. Хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэлтэй холбогдсон манай орны салбарын өнөөгийн хууль, эрх зүйн дэд актуудын зарим хэм хэмжээ нэг талаас бүрэн дүүрэн хэрэгжих боломжгүй, амьдралд нэг мөр хэрэгжиж хэвшээгүй, нөгөө талаар Үндсэн хуулийн зарчим, төрийн эрх зүйн бодлого, олон улсын эрх зүйн нийтлэг /жишиг/ хэм хэмжээ, чиг хандлагатай зөрчилдсөн, шийдвэрлэх олон асуудалтай болох нь судалгаанаас харагдлаа.
3. Өнөөгийн салбарын хуульд тусгагдсан хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрөл цөөн байгаа ба энэ нь тэдний үйлдсэн гэмт зан үйлийг зөв зүйлчилж тохирсон шийтгэл хүлээлгэх боломжийг хязгаарлаж эцэстээ хоригдогсдод оногдох сөрөг үр дагаварыг нэмэгдүүлж байна. Тухайлбал: Насанд хүрээгүй хорих ял эдлэгсдэд ээлжит бус ажил хийлгэх, хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх сахилгын шийтгэл хүлээлгэх боломжгүй,²⁰¹ улмаас зөвхөн сахилгын байранд хорих, тухайн улирал, эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах гэсэн шийтгэлийн аль нэгийг хэрэглэх, эсхүл асуудлыг шийдвэрлэлгүй орхих хууль зүйн практикийг бий болгодог.
4. Гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангид ял эдлэгсэд нэг талаас зөвхөн тухайн хорих ангийн үйлдвэрлэлд хөдөлмөр эрхлэх зохицуулалттай,²⁰² нөгөө талаас өнөө үед чанга дэглэмтэй хорих ангид ял эдлэгсдийн 50 орчим, онцгой дэглэмд -30 орчим, гянданд 10 орчим хувь нь л бодит байдалд ажлын байраар хангагдаж байгаа²⁰³

тул зөрчил гаргасан ялтны хувьд “хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх” сахилгын шийтгэл эцсийн дүндээ “ажилгүй болж амьдралын бүсд” үлдэх байдлаар хэрэгжиж байна.

Гэтэл “ажил хөдөлмөргүй байх нь” хорих ял эдлэгсдийн хувьд

- а/ хөдөлмөрийн хөлсгүй болох, үүний улмаас тэдний бусдад учруулсан хохирлыг төлүүлэх²⁰⁴, хорих ангийн дэлгүүрээс хүнсний болон нэн хэрэгцээт бусад зүйлсийг худалдан авах боломж нь хязгаарлагдах;
 - б/ хөдөлмөрийн дадал хэвшил, ур чадвараа сайжруулах, нийгэмших орчин нөхцөл нь тодорхой хэмжээнд хумигдах;
 - в/ илүү үр ашигтай өнгөрүүлж байсан цаг нь багасах;
 - г/ хөдөлмөрийн нормоо бүрэн биелүүлсэн, сахилгын зөрчил гаргаагүй зан байдал, хүмүүжил төлөвшлийнхээ төлөө авах боломжтой “шагналын хоног” авах боломжгүй болох;
 - д/ төлбөр нь барагдаагүй бол хугацаанаас өмнө суллагдах боломж үгүй болох зэрэг олон сөрөг үр дагавар-магадлалыг бий болгодог.
5. Сахилгын шийтгэлийн төрлөөс “сануулах” арга хэмжээг хассан нь эрх зүйн энэ институтын урьдчилан сэргийлэх үүргийг үгүй болгосон, мөн ялтаас зан үйлээ эргэн харах, засах боломжийг хязгаарласан гэж үзлээ.
 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, эрх зүйн холбогдох бусад хэм хэмжээний актад “сахилгын ноцтой зөрчил” гэсэн нэр томъёог тодорхойлоогүйн улмаас хорих байгууллагын алба хаагчид, прокурор, шүүгчдийн зүгээс үзэгдэлд янз бүрээр хандан хэрэгжүүлж байгаагаас зарим санал зөрөлдөөн, маргаан эдгээр хаагчид, ялтнууд хооронд үүссээр байна.²⁰⁵
 7. Сахилгын шийтгэлийн хуулийн түвшинд тусгагдвал зохих эрх зүйн хэм хэмжээний хийдэл,²⁰⁶ нөгөө талаас тэдгээрийн заримыг нөхөх оролдлогууд агуулга, хууль зүйн техникийн хувьд онол-эрх зүйн шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал: хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 270-р тушаал,²⁰⁷ ШШГЕГ-ын даргын 2010 оны А/73-р тушаалд,²⁰⁸ тус тус “ялтны сахилгын шийтгэлгүйд тооцох” журмыг тусган нь актуудын нэр,

анализ хийн үзвэл.

²⁰⁴ Энэ нь Эрүүгийн хуулийн 45.3-р зүйлд заасан: “эрүүгийн хариуцлагын зорилго болох ...гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх...” чиг үүргийг хангахад сөргөөр нөлөөлөх магадлал нэмэгдэнэ. //Төрийн мэдээлэл, 2002 он, №5

²⁰⁵ Судлаачдаас хийсэн социологийн судалгааны дүнд тулгуурласан.

²⁰⁶ Тухайлбал: хожуу илэрсэн сахилгын зөрчлийг ямар хугацаанд шийдвэрлэн шийтгэл хүлээлгэж болох, ямар тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй зэрэг асуудлыг үүнд хамруулж болно.

²⁰⁷ “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам”

²⁰⁸ “Ялтад шагналын хоног олгох, тэнсэн суллах, ялын дэглэмийг өөрчлөхөд мөрдөх журам”

²⁰¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 110.2 зүйлд: “Насанд хүрээгүй ялтныг хөдөлмөрийн дадлага олгох зорилгоор хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй нөхцөлд ажиллуулж болно.”

²⁰² Мөн хуулийн 120.6 зүйл

²⁰³ 2014 оны 02-р сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан “Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн зохицуулалт, чиг хандлага” сэдэвт ЭШХ-д ШШГЕГ-ын СҮХОГ-ын дарга хурандаа М.Хуягбаатарын тавьсан “Хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалтын асуудал” сэдэвт илтгэлд

зорилготой тохирохгүй байна.

Мөн сахилгын шийтгэлийг /төрлийг/ хэрэв зөрчлийн шинж чанар, ялтны хувийн байдалд тохируулан хүлээлгэдэг гэж үзвэл тэдгээрийн хууль зүйн үр дагаварууд өөр өөр байх учир зүй бий. Гэтэл асуудлыг дурьдсан эрх зүйн дэд актуудад нэг л хэмжээнд шийдвэрлэх боломжтойгоор тусгажээ.²⁰⁹

8. Өнөөдөр үйлчилж буй журамд²¹⁰ заасан манай орны сахилгын байрны нөхцөл нь зарим талаар олон улсын нийтлэг стандарт, чиг хандлага, эрх зүйн “хүнлэг-энэрэнгүй байх” зарчимтай зөрчилдөж²¹¹ байгаагийн зэрэгцээ эрүүгийн хариуцлагын зорилго, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

²⁰⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 270-р тушаалын хавсралт хэсгийн 6.3-р зүйлд: “Сахилгын байранд хоригдсон ялтан шийтгэлээ эдэлснээс хойш 1 жилийн дотор дахин зөрчил гаргаагүй, оногдсон ажлаа сайн гүйцэтгэсэн гэж үзвэл ахуй дэглэмийн байцаагчийн саналыг үндэслэн ангийн даргын тушаалаар сахилгын шийтгэлгүйд тооиж болно”. Мөн ШШГЕГ-ын даргын 2010 оны А/73-р тушаалын хавсралт хэсгийн 6.2-д: “Хорих анги, албанд ял эдэлж байгаа ялтан нь холбогдох хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэг журмыг зөвчиг сахилгын шийтгэл хүлээснээс хойш 1 жилийн хугааанд дахин зөрчил гаргаагүй тохиолдолд сахилгын шийтгэл арилсанд тооиж хуульд заасан урамшууллыг олгож болно” гэж заажээ. Харин эдгээр журмуудыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн 126-р зүйлийн 126.2-д заасан: “...урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө арилгах” гэсэн зохицуулалтын хүрээнд ШШГЕГ-ын даргын А/73-р тушаалын 6.4 /“Хугацаанаас өмнө гэдэгт 3 сарын хугацаа өнгөрсөн буюу 12 сар болоогүй байхыг ойлгоно”/-р зүйлийг оновчтой хэрэглэх практикаар л зөвтгөж болох юм. Гэтэл хорих анги, албадын дарга, алба хаагчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн бакалавр, магистр, докторын сургалтад суралцагчдаас авсан социологийн судалгааны дүнгээс үзвэл асуудлыг бодит байдалд нэг мөр ойлгон шийдвэрлэх практик /жишиг/ одоогоор тогтоогүй байна. Түүнчлэн эрх зүйн ерөнхий онол ёсоор “хуулийг үг-үсгээр нь хэрэглэнэ” гэж үзвэл журамд дурьдсан “ахуй дэглэмийн байцаагч” гэсэн албан тушаал 2002 оноос байхгүй болсон тул өнөөгийн “нийгмийн ажилтан”, “сэтгэл зүйч”-ийг энэ албан тушаалтантай шууд адилтган хэрэгжүүлэх боломжгүй юм.

²¹⁰ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 270-р тушаалын хавсралтаар батлагдсан “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам”

²¹¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1994 оны “Хоригдлын хоол, хувцас, ор дэр, цагаан хэрэглэл, ариун цэврийн хэрэгсэл, хорих газраас суллагдсан хүмүүст хувцас олгох норм, заавар батлах тухай” 25-р тушаалын хавсралт 1-д зааснаар: “... сахилгын хорих байранд байгаа ялтны хоолны илчлэг нь 1000 ккл байх бөгөөд хоолны материалд а/ гурилан талх-130 гр, б/ цагаанаас бусад будаа-80 гр, в/ мах-50 гр, г/ цай-5 гр, д/давс-10 гр, е/ төмс-200 гр, ё/ хүнсний ногоо-120 гр орох ёстой. Харин тэдний хоол хүнсэнд гурил, цагаан будаа, элсэн чихэр, сонгино, өөхөн тос тусгагдаагүй байна”. Хэдийгээр хорих ангиуд бодит байдалд сахилгын байрны ялтны хоолыг тусгайлан энэ жор, нормоор хийдэггүй, зөвхөн нийтийн хоолноос багасгасан нормоор өдөрт 2 удаа өгдөг боловч журмын зохицуулалтыг судлаачийн зүгээс хэт хүнлэг бус гэж үзэж байна.

хуулиар хорих байгууллагад хүлээлгэсэн зарим чиг үүргийг²¹² хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж гагцхүү “цээрлэл”-ийн шинж нь давамгайлсныг тэмдэглэж байна.

Тодруулбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 127-р зүйлийн 127.2 дахь хэсгийн²¹³ хүрээнд сахилгын байранд хоригдогч ялтнууд²¹⁴ журамд²¹⁴ зааснаар багасгасан нормоор хоол хүнс хэрэглэхийн гадна биедээ зөвхөн ариун цэврийн хэрэглэл /оо, саван, сойз/ авахыг зөвшөөрдөг²¹⁵ тул ном, сонин унших, телевиз үзэж, радио сонсох огт боломжгүй байна. Мөн “Ангийн дарга, дэд дарга, төлөөлөгчийн зөвшөөрлөөр сахилгын байранд зөвхөн ажлын 09.00-18.00 цагт харуул хамгаалалтын ажилтны хяналтын дор прокурор, ахуй дэглэмийн байцаагч, эрүүл ахуйн байцаагч, эмч нар нэвтрэн орж²¹⁶” уулзах боломжтой.

Энэ нөхцөлд хорих ял эдлэгсэд мэдээлэл авч мэдлэг, боловсрол, ажлын дадал, ур чадвараа дээшлүүлэх, нийгэмших явдал бараг боломжгүй гэж хэлж болно. Түүнчлэн журамд хууль хэрэглэх, тайлбарлах техникийн дүрмийн дагуу анализ хийн үзвэл “сахилгын байранд сэтгэл зүйч, нийгмийн ажилтууд нэвтрэн орж уулзах эрх зүйн боломж байхгүй байна”²¹⁷. Гэхдээ бидний хийсэн хэсэгчилсэн судалгаанаас: “хорих ангийн төлөөлөгч, дэд даргын хүлээлгэсэн үүргийн дагуу сахилгын байранд хоригдсон ялтан догшин авирлах, бие эрхтэндээ гэмтэл учруулах, амиа егүүтгэх оролдлого хийсэн, хийх магадлал буй үед сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд тэнд нэвтрэн орж асуудал, нөхцөл байдлыг тандах, тодруулах, үйлдлээс нь татгалзуулах зорилгоор хоригдогсдод сэнхрүүлэг-ухуулгын ажлыг хийдэг” нь тогтоогдсон.

Дэвшүүлсэн эдгээр дүгнэлт, жишээлэн авсан олон улсын эрх зүйн нийтлэг жишиг-хэм хэмжээ, гадаадын зарим орны зохицуулалтын чиг хандлагатай уялдуулан дараах **саналыг** гаргаж байна. Энэ нь:

1. Зөрчил гаргагч хорих ял эдлэгсдэд хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрлийг эрх зүйн хувьд

²¹² Энэ хуулийн 8.2.3-д заасан: “ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх”

²¹³ “Насанд хүрсэн эрэгтэй ялтныг 30 хүртэл хоног, насанд хүрээгүй болон эмэгтэй ялтныг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд насанд хүрсэн эрэгтэй ялтныг 60 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 30 хүртэл хоног сахилгын байранд хорино”.

²¹⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1994 оны 25-р тушаалаар батлагдсан дээр дурьдсан журам

²¹⁵ Хууль зүйн сайдын 2013 оны А/76-р тушаалын хавсралтаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”-ын 20.4 зүйл.

²¹⁶ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2002 оны 270-р тушаалын хавсралт хэсгийн 5.7 зүйл.

²¹⁷ Гэтэл эдгээр албан тушаалтны үндсэн үүрэг нь ялтанд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, асуудлаа шийдвэрлэх, нийгэмших үйл явцад туслан туслан зан байдалд нь эерэгээр нөлөөлөх явдал мөн. //“Хорих анги, -шийдвэр гүйцэтгэх албаны сэтгэл зүйчийн ажлын заавар” 2010.11.10 №А/106; Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар” 2010.11.10№А/107.

дараах арга замаар нэмэгдүүлэх²¹⁸:

- а) Нэг дэглэмийн хүрээнд хорих ял эдлэгсдийн тэмүүллийг татахуйц ялгамжгай хэд хэдэн нөхцөл бүхий хэсгүүдийг бий болгон хуульчилж үүнийг тэдний урамшуулал, сахилгын арга хэмжээтэй холбон ашиглах. Өөрөөр хэлбэл хорих ял эдлэгсдийн эерэг зан төлөвийг нь урамшуулан нэг дэглэмийн хүрээнд л гэхэд чангатгасан нөхцлөөс ердийн, ердийнхөөс хөнгөвчилсөн нөхцөл рүү, харин зөрчил гаргагч ялтныг сахилгын шийтгэлийн журмаар хөнгөвчилсөн нөхцлөөс ердийн, ердийнхөөс чангатгасан нөхцөлд шилжүүлдэг гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалтыг²¹⁹ авч хэрэглэх.
- б) Хүүхдийн бие физиологи, сэтгэл зүй, хөгжлийн зэрэг онцлогтой нь уялдуулан тэдэнд хүлээлгэх сахилгын шийтгэлийн тусгай төрлүүдийг хуульчлах. Гэхдээ судлаачийн зүгээс насанд хүрээгүй ял эдлэгсдэд сахилгын байранд хорих шийтгэлийг хүлээлгэхийн эсрэг байдаг.
- в) Сахилгын шийтгэлийн "сануулах" арга хэмжээг сэргээн хуульчлах.
- г) Зах зээлийн нийгэмтэй уялдуулан "сахилгын торгууль"-ийг шийтгэлийн төрөл болгох.
2. "Хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх" сахилгын шийтгэлийг ямар ч тохиолдолд "ялтныг ажил хөдөлмөр эрхлэхгүй болгох" хэмжээнд авч хэрэгжүүлэхгүй байх зохицуулалтыг хуульчлах.
3. Хуулийн түвшинд "сахилгын ноцтой зөрчил", "сахилгын шийтгэл хүлээлгэж болохгүй хугацаа"-г тодорхойлж өгөх.
4. Сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацааг шийтгэлийн төрөлтэй уялдуулан ялгамжтай байдлаар өнөөгийнхөөс хөнгөрүүлэн тогтоох /"богиносгох"/.
5. Сахилгын байранд хорих шийтгэлийг "зөвхөн цээрлэл"-ийн мөн чанараар хэрэгжүүлж байгаа өнөөгийн эрх зүйн зохицуулалт, практикийг халж нийгэмших тохирсон ажлыг явуулах боломжтой байдлаар хуульчлах. Тухайлбал: сахилгын байранд хоригдогч суралцах, спортоор хичээллэх, хүсвэл хөдөлмөрлөх, мөн нийгмийн

ажилтан, сэтгэл зүйч, өмгөөлөгч, хууль зүйн зөвөлгөө-туслалцаа үзүүлэх мэргэжилтэн, шашны байгууллагын ажилтантай уулзах, зан байдлаа эерэгээр өөрчлөх бичгээр гаргасан амлалтын үндсэн дээр хугацаанаас нь өмнө сахилгын байрнаас гаргах зэрэг зохицуулалтыг бий болгож болох юм.

6. Тухайн улирал, эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах өнөөгийн зохицуулалтыг "тодорхой хоногийг хасах" гэсэн ерөнхий томъёоллоор оруулж үр дагаварыг нь багасган хөнгөрүүлэх зэрэг болно.

Цаг заваа гарган тэвчээртэй уншиж сонирхсон та бүхэнд баярлалаа. Асуудлыг мэдэх, гүнзгийрүүлэн судлах, төгөлдөржүүлэхэд чиглэсэн саналыг илэрхийлэхийг хүссэн хэн нэгэнд бага боловч санаа өгсөн бол нийтлэлийн зорилго хангагдсанд тооцно.

Оюуны үр улам дэлгэрэх болтугай!

²¹⁸ Зорилго, ач холбогдлыг нийтлэлд дурьдсан.

²¹⁹ ОХУ-ын хувьд жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих байгууллагуудын хүрээнд хөнгөлөлттэй, ердийн, чангатгасан гэсэн нөхцөл бүхий хэсгүүдийг 2000 оноос бий болгосон нь ихээхэн үр дүнгээ өгч буй талаар олон бүтээлүүдэд дурьдсан байна. Мөн адил төстэй зохицуулалт Их британи, Франц, Герман зэрэг орнуудад байна. //ред. Ю.А.Калинина "Уголовно-исполнительное право: Учебник в 2 т. Т.2. особенная часть. М.2006., стр. 554-570. Мөн судлаачийн зүгээс хорих ял эдлэгсдэд олгох чөлөөг нэг дэглэмийн дотор дурьдсан нөхцөлтэй нь уялдуулан: гачигдлын, ердийн, амралтын өдрийн, баярын өдрийн, тэмдэглэлт өдрийн /тухайн ялтны, гэр бүлийн гишүүний төрсөн өдрийн, байгууллагын ойн зэрэг/, хүүхдүүдээ эргэхуулзах, суллагдахын өмнө ажлын байраа, амьдрах орон сууцны асуудлаа судлахад нь зориулан гэх мэтээр хуваан ялгамжтайгаар олгож болно гэж үздэг.